



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/136/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 88106992 Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.2 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Алдд-од. 18 № 2/47

танай _____ -ны № _____ -г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:\alban bichig\A4.docx

• 005020315

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

A handwritten signature in black ink is written over a red official stamp. The stamp is rectangular and contains Mongolian text and a central emblem. The signature is a stylized, cursive script that extends across the stamp and to the right.

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>63,672,144.83</u>	<u>66,320,021.84</u>
33	АВЛАГА	10,418,740.99	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	533,740.99	00.00
335	Бусад авлага	9,885,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	9,885,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	53,253,403.84	66,320,021.84
351	Түүхий эд материал	10,435,420.00	15,404,595.00
35110	Тусгай зориулалттай материал	8,945,920.00	10,924,245.00
35130	Эм боох материал	1,489,500.00	4,480,350.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	00.00	123,049.00
354	Хангамжийн материал	42,817,983.84	50,792,377.84
35410	Бичиг хэргийн материал	3,235,200.00	2,611,392.00
35420	Аж ахуйн материал	24,694,600.39	25,121,102.39
35450	Барилгын засварын материал	2,477,500.00	406,000.00
35460	Хүнсний материал	00.01	9,200.01
35470	Бусад хангамжийн материал	12,410,683.44	22,644,683.44
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>866,838,741.51</u>	<u>3,101,302,848.39</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	866,838,741.51	3,101,302,848.39
392	Биет хөрөнгө	847,120,741.51	3,081,584,848.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	742,130,700.00	2,974,323,350.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-59,113,343.78	-95,230,095.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00.00	25,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	134,238,680.60	145,105,792.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-55,999,626.86	-66,617,872.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	113,971,927.29	131,171,949.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	-41,379,287.62	-43,694,891.93
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,230,060.00	12,230,060.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,609,018.12	-4,832,024.16
39217	Ном	4,650,650.00	4,128,580.00
393	Биет бус хөрөнгө	19,718,000.00	19,718,000.00
39301	Программ хангамж	850,000.00	850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-850,000.00	-850,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	19,718,000.00	19,718,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>930,510,886.34</u>	<u>3,167,622,870.23</u>
413	Өглөг	10,808,060.00	248,989.22
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	10,763,060.00	248,989.22
4136	Бусад өглөг	45,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	45,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>919,702,826.34</u>	<u>3,167,373,881.01</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	919,702,826.34	3,167,373,881.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	468,392,438.00	468,392,438.00
51101	Өмч: - төрийн	468,392,438.00	468,392,438.00
512	Хуримтлагдсан үр дүн	77,112,879.21	2,324,783,933.88
51210	Өмнөх үеийн үр дүн	77,112,879.21	77,112,879.21
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,247,671,054.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	374,197,509.13	374,197,509.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>930,510,886.34</u>	<u>3,167,622,870.23</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	742,732,691.87	2,954,341,307.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	115,683,871.87	2,274,881,855.00
120	Нийтлэг татварын бус орлого	115,683,871.87	2,274,881,855.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	115,683,871.87	2,274,881,855.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	115,683,871.87	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	00.00	2,271,593,530.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		3,288,325.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	143,793,820.00	165,047,552.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	483,255,000.00	514,411,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	483,255,000.00	514,411,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,197,820.00	28,349,852.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,197,820.00	28,349,852.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,000,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	100,596,000.00	136,697,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	100,596,000.00	136,697,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	625,471,722.20	705,627,302.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	625,471,722.20	705,627,302.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	608,381,604.01	673,648,682.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	344,421,843.11	365,222,678.14
210101	Үндсэн цалин	244,675,176.29	282,383,878.14
210102	Нэмэгдэл	47,000,954.19	55,751,100.00
210104	Урамшуулал	52,745,712.63	27,087,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,978,452.88	46,798,603.24
210201	Тэтгэврийн даатгал	30,101,669.19	33,116,533.43
210202	Тэтгэмжийн даатгал	3,528,220.27	3,673,229.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,799,055.69	2,921,780.80
210204	Ажилгүйдлийн даатгал	595,408.80	644,278.27
210205	Эрүүл мэндийн даатгал	5,954,098.94	6,442,781.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	108,358,724.19	125,183,629.22
210301	Гэрэл, цахилгаан	3,592,974.19	6,219,913.22
210302	Түлш, халаалт	104,363,850.00	118,963,716.00
210303	Цэвэр, бохир ус	401,900.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,902,540.00	10,537,548.00
210401	Бичиг хэрэг	2,261,900.00	3,096,750.00
210402	Тээвэр, шатахуун	3,876,550.00	2,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	90,000.00	72,500.00
210404	Ном, хэвлэл	94,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	231,490.00	850,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	348,600.00	4,418,298.00

Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	33,202,430.00	52,861,851.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,000.15	1,618,950.00
210502	Хоол, хүнс	32,720,729.85	51,242,901.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	436,700.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	801,700.00	3,954,900.00
210604	Урсгал засвар	801,700.00	3,954,900.00
2107	Томилолт, зочны зардал	957,000.00	142,000.00
210702	Дотоод албан томилолт	957,000.00	142,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	712,000.00	867,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	262,000.00	130,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	237,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,046,913.83	68,079,573.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,631,300.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	716,450.00	1,308,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,699,163.83	66,771,473.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,090,118.19	31,978,619.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,550,870.00	29,528,010.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	14,292,630.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,197,820.00	13,949,880.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,353,050.00	1,285,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	335.81	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	335.81	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,538,912.38	2,450,609.61
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,538,912.38	2,450,609.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	117,260,969.67	2,248,714,004.67
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,042,950.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	1,042,950.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,042,950.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	117,260,969.67	2,247,671,054.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	627,048,820.00	679,459,452.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	627,048,820.00	679,459,452.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	483,255,000.00	514,411,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,197,820.00	28,349,852.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,197,820.00	28,349,852.00

Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,000,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	100,596,000.00	136,697,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	100,596,000.00	136,697,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	605,405,720.00	658,659,452.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	605,405,720.00	658,659,452.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	582,243,801.81	615,072,782.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	338,480,813.62	365,795,740.39
210101	Үндсэн цалин	238,734,146.80	282,956,940.39
210102	Нэмэгдэл	47,000,954.19	55,751,100.00
210104	Урамшуулал	52,745,712.63	27,087,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,397,200.00	45,691,800.00
210201	Тэтгэврийн даатгал	32,379,700.00	35,833,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,886,500.00	2,464,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,968,300.00	1,971,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	742,000.00	493,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,420,700.00	4,929,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,595,664.19	135,697,700.00
210301	Гэрэл, цахилгаан	3,592,974.19	8,982,973.22
210302	Түлш, халаалт	93,600,790.00	126,714,726.78
210303	Цэвэр, бохир ус	401,900.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,108,240.00	7,297,700.00
210401	Бичиг хэрэг	1,521,500.00	1,567,400.00
210402	Тээвэр, шатахуун	3,320,550.00	2,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	670,400.00	580,000.00
210404	Ном, хэвлэл	206,000.00	129,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	231,490.00	850,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,158,300.00	2,070,500.00
2105	Нормативт зардал	38,533,630.00	54,864,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,292,600.00	3,589,300.00
210502	Хоол, хүнс	26,501,730.00	39,736,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,739,300.00	11,538,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,266,000.00	2,833,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,300,000.00	00.00
210604	Урсгал засвар	6,966,000.00	2,833,200.00
2107	Томилолт, зочны зардал	957,000.00	142,000.00
210702	Дотоод албан томилолт	957,000.00	142,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	667,000.00	1,020,242.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	217,000.00	280,242.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,238,254.00	1,730,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,532,500.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,705,754.00	1,730,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,161,918.19	43,586,669.61

Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	11,622,670.00	41,136,060.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,171,800.00	11,638,550.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	14,292,630.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,197,820.00	13,949,880.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,253,050.00	1,255,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	335.81	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	335.81	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,538,912.38	2,450,609.61
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,538,912.38	2,450,609.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	21,643,100.00	20,800,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	21,643,100.00	20,800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,643,100.00	20,800,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,643,100.00	20,800,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,643,100.00	20,800,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-21,643,100.00	-20,800,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	448,674,438.00	274,344,647.96	-49,002,510.40	674,016,575.56
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	448,674,438.00	274,344,647.96	-49,002,510.40	674,016,575.56
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	9,022,278.46	9,022,278.46
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	468,392,438.00	374,197,509.13	77,112,879.21	919,702,826.34
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	468,392,438.00	374,197,509.13	77,112,879.21	919,702,826.34
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	468,392,438.00	374,197,509.13	77,112,879.21	919,702,826.34
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,247,671,054.67	2,247,671,054.67
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	468,392,438.00	374,197,509.13	2,324,783,933.88	3,167,373,881.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	651,109,600.00	648,658,990.39	2,450,609.61	99.62

Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	651,109,600.00	648,658,990.39	2,450,609.61	99.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	636,025,700.00	635,765,440.39	260,259.61	99.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	365,811,700.00	365,795,740.39	15,959.61	100.00
210101	Үндсэн цалин	282,972,900.00	282,956,940.39	15,959.61	99.99
210102	Нэмэгдэл	55,751,100.00	55,751,100.00	0.00	100.00
210104	Урамшуулал	27,087,700.00	27,087,700.00	0.00	100.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,809,600.00	45,691,800.00	117,800.00	99.74
210201	Тэтгэврийн даатгал	35,676,600.00	35,833,100.00	-156,500.00	100.44
210202	Тэтгэмжийн даатгал	2,533,300.00	2,464,700.00	68,600.00	97.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,026,600.00	1,971,300.00	55,300.00	97.27
210204	Ажилгүйдлийн даатгал	506,700.00	493,400.00	13,300.00	97.38
210205	Эрүүл мэндийн даатгал	5,066,400.00	4,929,300.00	137,100.00	97.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135,697,700.00	135,697,700.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	3,949,300.00	8,982,973.22	-5,033,673.22	227.46
210302	Түлш, халаалт	131,127,400.00	126,714,726.78	4,412,673.22	96.63
210303	Цэвэр, бохир ус	621,000.00	00.00	621,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,711,700.00	7,597,700.00	114,000.00	98.52
210401	Бичиг хэрэг	1,567,400.00	1,567,400.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	2,100,000.00	2,100,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	644,000.00	580,000.00	64,000.00	90.06
210404	Ном, хэвлэл	429,800.00	429,800.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	767,200.00	850,000.00	-82,800.00	110.79
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,203,300.00	2,070,500.00	132,800.00	93.97
2105	Нормативт зардал	54,864,300.00	54,864,300.00	0.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,589,300.00	3,589,300.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	39,736,600.00	39,736,600.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,538,400.00	11,538,400.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,333,200.00	23,333,200.00	0.00	100.00
210602	Тавилга	20,500,000.00	20,500,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	2,833,200.00	2,833,200.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	154,500.00	142,000.00	12,500.00	91.91
210702	Дотоод албан томилолт	154,500.00	142,000.00	12,500.00	91.91
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	912,900.00	912,900.00	0.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	172,900.00	172,900.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1730100.00	1730100.00	0.00	100.00

Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,730,100.00	1,730,100.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,083,900.00	12,893,550.00	2,190,350.00	85.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,083,900.00	12,893,550.00	2,190,350.00	85.48
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,788,500.00	11,638,550.00	2,149,950.00	84.41
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,295,400.00	1,255,000.00	40,400.00	96.88
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	651,109,600.00	648,658,990.39	2,450,609.61	99.62
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	514,411,900.00	511,961,290.39	2,450,609.61	99.52
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	514,411,900.00	511,961,290.39	2,450,609.61	99.52
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	136,697,700.00	136,697,700.00	0.00	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	136,697,700.00	136,697,700.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	33.00	33.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	34.00	34.00	0.00	100.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	20.00	20.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14.00	14.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,197,820.00	28,349,852.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,197,820.00	28,349,852.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,197,820.00	28,349,852.00
2109	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,197,820.00	107,342.00
210901	Бараа үйлчилгээний зардал	43,197,820.00	107,342.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,197,820.00	28,242,510.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,197,820.00	28,242,510.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	14,292,630.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,197,820.00	13,949,880.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	39,000,000.00	107,342.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,000,000.00	107,342.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,000,000.00	107,342.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 84 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд сургуулийн захирал Ж.Болормаа нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч С.Түмэнжаргал нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Тус сургууль нь “Хүүхэд нэг бүрийг сурлагын хоцрогдолгүй тэгш хамруулан сургаж, дижитал технологийг хичээлд сургалтдаа нэвтрүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын доор үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/37 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөж байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 625,713.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,385.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,508.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 8,467.5 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 3,167,622.8 мянган төгрөг болж өмнөх оноос 2,237.1 мянган төгрөгөөр буюу 70.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
A	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	63,672.10	66,320.00	2,647.90
Мөнгөн хөрөнгө	-	-	0.00
Авлага	10,418.70	0.00	-10,418.70
Урьдчилгаа	-	-	0.00
Бараа материал	53,253.40	66,320.00	13,066.60
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	866,838.70	3,101,302.80	2,234,464.10
Үндсэн хөрөнгө	1,027,790.00	3,312,527.70	2,284,737.70
Хуримтлагдсан элэгдэл	-160,951.20	-211,224.80	-50,273.60
Нийт хөрөнгө	930,510.80	3,167,622.80	2,237,112.00
Өр төлбөр	10,763.0	248.9	10,514.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	919,702.80	3,167,373.80	2,247,671.00
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	930,510.80	3,167,622.80	2,237,112.00

Бараа материалын дансны үлдэгдэл 66,320.0 мянган төгрөг болж 13,066.6 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материалын үлдэгдэл өмнөх оноос 10,234.0 мянга, эм боох материалын үлдэгдэл 2,990.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба Дээд шатны төсөв захирагчаас шилжүүлж ирсэн 3,288.3 мянган төгрөгийн биеийн тамирын хичээлийн хэрэгсэл, сурах бичгүүдийг хүлээн авсан зэрэг өмнөх оноос өссөн нь бараа материал голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,312,527.7 мянган төгрөг болж 2,284,737.7 мянган төгрөгөөр өссөн нь дээд шатны төсөв захирагчаас шилжиж ирсэн тоног төхөөрөмж 14,215.0 мянга, тавилга хэрэгсэл 7,690.0 мянга, төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж 1,000.0 мянга, дотуур байрны хүүхдийн ор 19,500.0 мянган төгрөгөө худалдан авч авч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271-р тогтоолын 4.1.1-д заасны дагуу холбогдох дансанд орлогоор бүртгэсэн мөн УТХО-аар баригдсан 240 хүүхдийн сургуулийн барилгыг 2,149,352.6 мянга, Байшинтыг таг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраас фургон автомашин 25,000.0 мянга, өмнөх оны санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн 9,885.0 мянган төгрөгийн ухаалаг самбарыг тус тус холбогдох дансанд орлогоор бүртгэж 17,540.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Тайлант онд 248.0 мянган төгрөгийн өглөг үүссэн нь халаалтын зардлаас гэрэл цахилгааны зардалд батлагдсан төсөв гүйлгэн зарцуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,167,373.8 мянган төгрөг болж 2,247,671.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 2,247,671.0 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 653,053.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 653,053.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 126,565.9 мянган төгрөгөөр бууруулж 526,469.6 мянган төгрөгөөр анх батлагдсан ба 2021 оны 12 дугаар сард төсөвт зохицуулалт хийгдэж 651,109.6 мянган төгрөг болж 124,640.0 мянган төгрөг буюу 19.1 хувиар өсөж батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 651,109.6 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 514,411.9 мянга, орон нутгийн төсвөөс 136,697.7 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 514,411.9 мянга, орон нутгийн төсвөөс 136,697.7 мянга нийт 651,109.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 648,658.9 мянган төгрөгийг зарцуулж 2,450.6 мянган төгрөг буюу 0.3 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 648,658.9 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь үдийн цайны зардал 2,450.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн Төрийн сан банкин дахь 100030215401 тоот дансанд БСУГ-аас хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 13,949.8 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 14,292.6 мянга, шалгалтын бичиг хэргийн зардалд 107.3 мянган төгрөгийг олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 20 зорилт 141 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 90%-тай гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 705,627.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 80,155.6 мянган төгрөгөөр буюу 11,3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь хангамжийн материал өмнөх оноос буурсан бол бусад зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн системд нийт 651,109.6 мянган төгрөгийн 151 мэдээлэл байршуулахаас хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс 421,919.2 мянган төгрөгийн 25 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	6	3	2
2	Хагас жил	4	4	3	1	0
3	Улирал бүр	1	4	3	1	0
4	Сар бүр	3	36	34	2	0
5	Тухай бүр	8	96	78	18	0
	Нийт	27	151	124	25	2

3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Урсгал төсвийн зарцуулалт нь гүйцэтгэлээр улсын төсвөөс 514,411,9 мянга, орон нутгийн төсвөөс 136,697.7 мянга нийт 651,109.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 648,658.9 мянган төгрөгийг зарцуулж 2,450.6 мянган төгрөг буюу 0.3 хувийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд тогтмол зардалд 135,697.7 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 27,139.5 мянган төгрөг байхад хэмнэлт үүсээгүй байгаа нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 14,284.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 775.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 13,509.4 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 заалт бүхий зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажиллаж хэрэгжилтийн тайланг 2021 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах аяны хүрээнд шалгасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа илэрч зөрчил давтан гаргахгүй байх 7,492.6 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 3 заалт бүхий зөвлөмжийг хүргүүллээ.

4.2 Зөвлөмж

4.2.1 Тайлант онд тогтмол зардалд 135,697.7 мянган төгрөг батлагдаж 126,714.7 мянган төгрөгийг зарцуулж 4,412.6 мянган төгрөгийн хэмнэлт үүсэн боловч гэрэл цахилгааны зардал хэтэрсэн учир тус зардалд гүйлгэн зарцуулснаас тогтмол зардалд хэмнэлт гаргаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Цаашид төсвийн захирагч болон дээд шатны байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг мөрдөн хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулж ажиллах.

4.2.2 Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс тухай бүр оруулахаас 421,919.2 мянган төгрөгийн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ өссөн дүнгээр хөрөнгө оруулалт, тендерийн ерөнхий мэдээлэл зэрэг 25 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.4, 6.4.5 дахь хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх, удирдлагаас түүнд тавих хяналтыг сайжруулах.

4.2.3 Ковид-19 өвчлөлийн түргэвчилсэн оношлуурын тестийг үлдэгдэл 100ш байхад 2021.12.23-ны өдөр нэмж 100ш-г 1380,0 мянган төгрөгийн худалдан авч төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 10.1.11.төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах; гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Цаашид хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлж төсвийн хөрөнгийг үр ашигтай байхаар төлөвлөж холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баян-Овоо сумын ЕБС	3	7,492.6	0	0	0	0	0	0	3	7,492.6

_____оОо_____